Мөрөөдлөө
Санхүүжүүл

InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП



# ИНВЕСКОР ББСБ ХК
# 2021 ОНЫ
# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ГОЛ АМЖИЛТУУД

Чанарын удирдлага **(ISO9001)** болон мэдээллийн аюулгүй байдлын **(ISO27001)** стандартыг нэвтрүүлж байна.

1.2 тэрбум **төгрөг**

Нэгж хувьцаанд 17 төгрөг буюу нийт **1.2 тэрбум** төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараасан.

“Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран **“Жижиг дунд бизнес”** эрхлэгчдэд зориулсан бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн санал болгож байна.

“Инвескор ББСБ” ХК нь **Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ToC)**-нд үндсэн гишүүнээр элссэн.

“Инвескор ББСБ” ХК нь биржийн **“Нэг дүгээр ангилал”**-д дэвшин орлоо.

“Инвескор Санхүүгийн Групп” нь Токио-2020 зуны олимпын наадмын шууд дамжуулалтын **“Алтан Ивээн Тэтгэгч”**-р ажилласан.

## ГОЛ АМЖИЛТУУД

Олон улсад 100+ улсын 2,000+ санхүүгийн байгууллагуудын рейтинг тогтоосон **“MicroFinanza Rating”** SRL байгууллагаас Монгол улсдаа хамгийн өндөр **“A- High”** үнэлгээ авлаа.

Хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн том бөгөөд анхны нээлттэй **20 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөр**ийг хэрэгжүүлж 100% амжилттай хөрөнгө татан төвлөрүүллээ.

“EMF MICROFINANCE FUND”-с **3.0 сая** ам.долларын урт хугацаат зээлийн санхүүжилт амжилттай татлаа.

“Инвескор Хэтэвч ББСБ” ХХК нь өөрийн Покет платформыг **“Market Place”** хэлбэрт шилжүүлж бусад Банк болон ББСБ-уудад санал болгож эхэллээ.

## КОМПАНИЙН БҮТЭЦ

2016

**“ИНВЕСКОР ББСБ” ХК**

100% 2020

**“ИНВЕСКОР СИ ЭЙ” МФК**

Киргиз улс дахь бичил санхүүгийн компани.

100% 2020

**“ПОКЕТ КГ” ХХК**

Киргиз улсын зах зээлд Покет платформыг нэвтрүүлж байна.

100% 2019

**“ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ” ХХК**

Покет платформоор дамжуулан дижитал зээл, хэтэвч, мөн төлбөрийн хэрэгслийн үйл ажиллагаа явуулж байна.

75% 2020

**“ИНВЕСКОР АКТИВ” ТЗК**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан тусгай зориулалттай компани.

# ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

## Зээлийн багц, харилцагчийн тоо




## Зээлийн багц (бүтээгдэхүүнээр %)




## Зээлийн багцын чанар



## БОРЛУУЛАЛТЫН СУВАГ




### +5 салбар

Инвескор ББСБ ХК нь 2021 онд шинээр 5 салбар нээж нийт 18 салбартай боллоо.

### Байршил

Үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Эрдэнэт хотод, 1 нь цахим хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

### 4 аймаг

Инвескор Аллианс төсөл нь Монгол улсын 4 аймагт тус бүр нэг гишүүн ББСБ-тай боллоо.

## ПОКЕТ - ДИЖИТАЛ ЗЭЭЛ

2021 онд Покет платформ нь "Цахим зээлийн төв" болж бусад банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад өөрийн технологийн шийдэл, бусад давуу талуудаа санал болгож эхэллээ. Оролцогч санхүүгийн байгууллагууд Покет платформоор дамжуулан өөрийн зээлийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд цахимаар буюу илүү хялбар аргаар хүргэх бөгөөд мөн Покет аппликэйшн нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тэгс нийцсэн бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг өөртөө багтаасан байна.

### Гол Бүтээгдэхүүн, Үйлчилгээ

pocket

33.7 тэрбум төгрөгийн зээлийн багцтай, 146 мянган идэвхтэй зээл

**Pocket Loan**

pocket

Цахим төлбөр тооцооны 500 мянга + бүртгэлтэй хэрэглэгч

**Pocket Pay**

pocket coupon

155+ нэр төрлийн купон, 150+ хамтрагч байгууллага

**Pocket Coupon**

pocket ZERO

211+ Мерчант байгууллага, 200+ Брэнд, 400+ салбар

**Pocket Zero**

### PCI DSS - Олон Улсын Стандарт

Инвескор Хэтэвч ББСБ ХХК-ийн цахим зээл, цахим төлбөр тооцооны Pocket аппликэйшн нь төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) олон улсын стандартыг бүрэн хангаж батламжаа хүлээн авлаа.


pocket — SISA

| | |
|---|---|
| Name of Company | Invescore Wallet NBFI LLC |
| Certificate Number | PCI/COC/ICW27021 |
| Address | 15th Floor, Twin Tower 1, Seoul Street, 2nd Khoroo, Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongolia - 14251 |
| Scope | Pocket Application |
| Type of Certification | PCI DSS v3.2.1 (Level 1 Service Provider) |
| Category | Service Provider |
| Certification Status | Active |

SISA PCI DSS Certified

Disclaimer:

SISA Information Security makes no representation or warranty as to whether the validated or certified company systems are secure from either an internal or external attack or whether cardholder data is at risk of being compromised. SISA Information Security makes no representations or warranties on the business activities or operations of the said company. Please contact the company displaying the seal if you have questions about their products, services or customer support.

Copyright © 2003-2021. SISA. Ph:+1 209 497 4604 . info@sisainfosec.com

## ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Ковид-19 цар тахлын үед Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг “Инвескор ББСБ” ХК нь “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

## ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| 30 **сая хүртэл** | Нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ |
| 4.8 **Хувь** | Зээлийн жилийн хүү |
| 24 **сар хүртэл** | Зээлийн хугацаа |
| 0.0 **Хувь** | Зээл судалсны шимтгэл |

### 2021 оны үр дүн

- **1.1** тэрбум төгрөгийн зээл олголт
- **46** ААН болон иргэн
- **21** салбарын бизнес эрхлэгчид
- Нийт харилцагч нарын **85%** нь үйлдвэрлэл эрхэлдэг

### Зээлдэгчид тавигдах шаардлага

- Үйлдвэрлэл үйлчилгээний бизнес эрхэлдэг байх;
- Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг байх;
- 6 сар ба түүнээс дээш хугацаагаар идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байх



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

Инвескор ББСБ ХК нь олон улсад зах зээлээ тэлэх стратегийн хүрээнд Киргиз улсад 2 охин компани (“Invescore CA” MFC, “Pocket KG” LLC) байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь хурдацтай тэлж, өргөжиж байна.

## “INVESCORE CA” MFC

2021 онд 3 салбар шинээр нээж, нийт 21 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Мөн Киргиз Улсын Төв банкнаас олгосон тусгай зөвшөөрлөө шат ахиулж “Бичил санхүүгийн компани” лицензтэй 10 компанийн нэг боллоо. Ингэснээр нэг харилцагчид олгох зээлийн хэмжээ нэмэгдэхээс гадна итгэлцэл татах, факторинг, гадаад арилжаа, баталгаа гаргах зэрэг бусад үйлчилгээг Киргиз Улсад явуулах эрхтэй болж байгаа юм.

2021 оны үр дүн болон өмнөх онтой харьцуулахад:

- Цэвэр зээлийн багц 6.8 тэрбум төгрөгт хүрч 183%-иар өссөн.
- Нийт хөрөнгө 7.9 тэрбум төгрөгт хүрч 148%-иар өссөн.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2.6%, Чанаргүй зээлийн хувь 0.3%-тай байна.
- Нийт зээлийн тоо 832-т хүрч 228%-иар өссөн.




## “Pocket KG” LLC

Покет платформыг Киргиз улсын зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2022 оны нэгдүгээр улиралд багтаан цахим зээлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгч нарт санал болгож эхлэнэ.

2021 оны эцсийн байдлаар эдийн засгийн орчин болон зах зээлийн судалгаа, системийн хөгжүүлэлт, төрийн байгууллагуудын системийн холболт, аппликэйшны туршилт зэрэг ажлууд амжилттай хийгдэж дуусаад байна.



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### Эрүүл мэндийн даатгал

Инвескор ББСБ ХК нь нийт ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг байсан ба 2021 онд группийн хэмжээнд бүх ажилтнуудаа үнэ төлбөргүй Эрүүл мэндийн даатгалд хамрууллаа. Мөн, ажилтнууд хөнгөлөлттэй үнээр гэр бүлийнхээ гишүүдийг давхар хамруулж болох боломж олголоо.




### 1,000,000 мод

Ногоон хөгжил, байгаль экологийн асуудал дэлхий даяар тулгамдаад байгаа энэ цаг үед Монгол улсын хэмжээнд 2030 он хүртэл 1 тэрбум мод тарих том амлалтыг өгсөн билээ. Инвескор Санхүүгийн Групп нь энэ ажлын хүрээнд 1 сая мод тарьж хувь нэмрээ оруулах амлалт өглөө. Их хэмжээний мод тарьж, ургуулахад шаардлагатай судалгаа шинжилгээ, санхүүжилт, хүний нөөц, менежментийг бүрэн шийдвэрлэхийн тулд бид мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахаар төлөвлөөд байна.



# САНХҮҮГИЙН ҮР ДҮН

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ /мянган ₮/

| | 2019 он | 2020 он | 2021 он |
|---|---|---|---|
| | *Аудитлагдсан* | *Аудитлагдсан* | *Аудитлагдсан* |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 5,146,145 | 26,588,673 | 24,638,751 |
| Хөрөнгө оруулалт | 3,599,750 | 591,122 | 183,583 |
| **Харилцагчдад олгосон зээл-цэвэр** | **60,645,316** | **92,548,329** | **170,045,509** |
| Нийт зээл | 61,950,468 | 95,290,684 | 173,192,374 |
| Эрсдэлийн сан | 1,305,152 | 2,742,355 | 3,146,865 |
| Хүүний авлага | 1,662,559 | 3,861,472 | 5,463,307 |
| Авлага | - | 1,534,116 | 3,274,706 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 1,055,576 | 821,892 | 783,568 |
| Бусад актив | 2,309,789 | 492,218 | 1,980,060 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 7,483,027 | 9,502,698 | 5,852,811 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **81,902,162** | **135,940,520** | **212,222,295** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 19,933,800 | 42,209,511 | 56,477,725 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 14,515,976 | 14,100,000 | 44,615,994 |
| Бонд | - | 7,878,886 | 27,620,907 |
| Бусад өглөг | 7,063,692 | 19,055,331 | 7,990,906 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **41,513,468** | **83,243,728** | **136,705,532** |
| Хувьцаат капитал | 16,282,237 | 16,282,237 | 16,282,237 |
| Нэмж төлөгдсөн капитал | 15,377,738 | 15,377,738 | 15,377,738 |
| Хоёрдогч өглөг | - | - | 5,000,000 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 8,728,719 | 21,036,819 | 38,856,788 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **40,388,694** | **52,696,794** | **75,516,763** |
| **Нийт пассив ба өөрийн хөрөнгө** | **81,902,162** | **135,940,522** | **212,222,295** |

## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ /мянган ₮/

| | 2019 он | 2020 он | 2021 он |
|---|---|---|---|
| **Хүү болон түүнтэй адилтгах орлого** | **19,362,985** | **29,147,505** | **41,122,071** |
| **Хүү болон түүнтэй адилтгах зардал** | **4,192,760** | **6,755,193** | **12,814,237** |
| Бусад хүүгийн зардал | 2,107,869 | 2,593,650 | 5,336,908 |
| Итгэлцлийн үйл ажилллагааны зардал | 2,084,891 | 4,161,543 | 7,477,329 |
| **Хүүгийн цэвэр орлого** | **15,170,225** | **22,392,312** | **28,307,834** |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 2,600,157 | 450,277 | 8,886,652 |
| Гадаад валютын арилжааны орлого/зардал | 159,154 | - | - |
| **Нийт хүүгийн бус цэвэр орлого** | **2,759,311** | **450,277** | **8,886,652** |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | **17,929,536** | **22,842,589** | **37,194,486** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | 3,000,568 | 3,170,017 | 5,759,249 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 3,664,400 | 4,116,052 | 6,455,882 |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | **6,664,968** | **7,286,069** | **12,215,131** |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардал | - | 86,738 | (157,173) |
| **Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал** | **11,264,568** | **15,643,258** | **24,822,182** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 56,963 | 1,297,947 | 743,455 |
| **Татварын өмнөх ашиг** | **11,207,605** | **14,345,311** | **24,078,727** |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 16,463 | (655,081) | (368,409) |
| Орлогын албан татвар | 2,548,913 | 2,285,986 | 4,518,782 |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | **8,675,155** | **11,404,244** | **19,191,536** |

## ХУВЬЦААНЫ ХАНШ




| | |
|---|---|
| **Үнэт цаасны код** | INV |
| **Зах зээлийн үнэлгээ** | 290 тэрбум төгрөг |
| **Гаргасан хувьцааны тоо ширхэг** | 71,727,918 ширхэг |
| **Хаалтын ханш /2021.12.31/** | 4,043.0 төгрөг |
| **IPO-с хойших өсөлт** | 145% |

**Хувьцааны ханш:** 4043₮

**2021 оны өсөлт:** 37% ↑

**IPO-с хойш:** 145% ↑

“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекст багтдаг ба 2021 оны 9 сард хувьцааны бүртгэлийн II ангиллаас I ангилал руу ахисан амжилттай байна.

## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

| Шалгуур үзүүлэлт | Байх ёстой | 2020 аудитлагдсан | 2021 аудитлагдсан |
|---|---|---|---|
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-иас доошгүй | 39.1% | 30.7% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-иас доошгүй | 39.1% | 33.1% |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-иас доошгүй | 37.3% | 31.7% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-иас дээш | 34.5% | 16.2% |
| Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 30%-иас хэтрэхгүй | 7.7% | 11.7% |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-иас хэтрэхгүй | 0.0% | 0.0% |
| Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 25%-иас хэтрэхгүй | 0.6% | 0.4% |
| Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө | 10%-иас хэтрэхгүй | 0.1% | 0.0% |
| Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө | 50%-иас хэтрэхгүй | 12.4% | 8.5% |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | +/-40%-иас хэтрэхгүй | 18.4% | 18.0% |
| Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-иас хэтрэхгүй | 78.1% | 74.7% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-иас хэтрэхгүй | 15.3% | 38.5% |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-иас хэтрэхгүй | 3.5% | 0.9% |